

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/075/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Назгүл
Утас: 88403281 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ..... | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 11 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 15 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 15 |
| 4.2 Материаллаг байдал..... | 15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 15 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 16 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 16 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 16 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 17 |
| 5.1 Төлбөрийн акт..... | 17 |
| 5.2 Албан шаардлага..... | 17 |
| 5.3 Зөвлөмж..... | 17 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ТТӨХ | Тоног төхөөрөмж |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ж.АЛИМА ТАНАА

2025.02.25 № 312
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Санхүүгийн тайланд үдийн хоолны зардлын гүйцэтгэлийг 211.5 сая төгрөгөөр тайлагнаж, хүүхдийн тоог 1-5 дугаар сард 850, 9-12 дугаар сард 886 хүүхдээр тогтмол тоогоор тооцсон, хүүхдийн бүртгэлийг өдөр тутам хянаж, баримтжуулаагүй, нярвын 1-9 дүгээр сарын хүнсний материалын тайлан, анхан шатны зарлагын баримтаар тогоочид олгосон материалын зарцуулалтыг хоолны талонтой тулгаж үзэхэд 10.2 сая төгрөгийн материалыг баримтгүйгээр илүү зарлага гаргаж, санхүүгийн тайланд тусгасан, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3 дэх хэсгийн, 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн,

20.1.1, 20.1.4 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд 5,661.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 5,169.9 сая төгрөг зарцуулж, 93 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>503,178,274.00</u> | <u>418,317,648.46</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 438,556,800.00 | 326,151,640.66 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 438,556,800.00 | 326,151,640.66 |
| 3121 | Төгрөг | 438,556,800.00 | 326,151,640.66 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 438,556,800.00 | 326,151,640.66 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 64,621,474.00 | 92,166,007.80 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | 4,860,930.00 |
| 354 | Хангамжийн материал | 64,621,474.00 | 87,305,077.80 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 594,600.00 | 1,328,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 47,276,354.00 | 43,870,854.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 200,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 274,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 9,255,770.00 | 32,539,580.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,020,750.00 | 9,565,743.80 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>3,260,775,492.12</u> | <u>3,358,193,680.62</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,260,775,492.12 | 3,358,193,680.62 |
| 391 | Газар | - | - |
| 392 | Биет хөрөнгө | 3,205,380,253.20 | 3,302,924,603.70 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,431,624,670.00 | 3,458,352,670.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (543,285,871.74) | (687,794,731.91) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | - | - |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 215,235,868.00 | 407,573,758.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (72,019,379.67) | (92,113,846.79) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 251,189,479.80 | 286,697,594.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (104,425,757.23) | (123,568,158.44) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 14,010,952.00 | 40,727,026.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (12,827,817.96) | (12,827,817.96) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | - |
| 39217 | Ном | 25,878,110.00 | 25,878,110.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 55,395,238.92 | 55,269,076.92 |
| 39301 | Програм хангамж | 1,973,239.00 | 1,973,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (220,000.08) | (346,162.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 53,642,000.00 | 53,642,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>3,763,953,766.12</u> | <u>3,776,511,329.08</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | = | <u>51,612,400.00</u> |

| | | | |
|------------|--|--------------------------------|--------------------------------|
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 51,612,400.00 |
| 413 | Өглөг | - | 51,612,400.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 51,612,400.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 51,612,400.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>3,763,953,766.12</u> | <u>3,724,898,929.08</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,763,953,766.12 | 3,724,898,929.08 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 586,066,331.00 | 586,066,331.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 586,066,331.00 | 586,066,331.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,321,700,013.72 | 1,282,645,176.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,321,700,013.72 | 1,321,700,013.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (39,054,837.04) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,856,187,421.40 | 1,856,187,421.40 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>3,763,953,766.12</u> | <u>3,776,511,329.08</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 5,822,072,003.00 | 5,378,635,472.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,000,000.00 | 218,126,972.80 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,000,000.00 | 218,126,972.80 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 206,189,079.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 2,544,993.80 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,816,072,003.00 | 5,160,508,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,620,167,603.00 | 4,916,779,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,898,192,400.00 | 4,916,779,900.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 1,721,975,203.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 195,904,400.00 | 243,728,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 195,904,400.00 | 243,728,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,717,252,231.47 | 5,417,690,309.84 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,717,252,231.47 | 5,417,690,309.84 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,529,813,734.47 | 5,206,171,039.84 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,571,540,877.00 | 3,828,504,277.36 |
| 210101 | Үндсэн цалин | 1,694,745,006.00 | 2,515,001,131.36 |
| 210102 | Нэмэгдэл | 745,581,235.00 | 1,154,388,446.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 131,214,636.00 | 159,114,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 357,791,600.00 | 498,073,200.00 |

| | | | |
|-------------|--|--------------------------------|-------------------------------|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 243,298,000.00 | 338,689,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 28,623,500.00 | 39,845,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,898,600.00 | 19,923,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,724,700.00 | 19,923,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 57,246,800.00 | 79,691,800.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 195,934,422.00 | 295,541,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,850,237.00 | 11,397,021.86 |
| 210302 | Түлш, халаалт | 185,383,585.00 | 282,443,978.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,700,600.00 | 1,700,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 159,155,680.00 | 207,765,630.00 |
| 210502 | Хоол, хүнс | 159,155,680.00 | 207,765,630.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,376,500.00 | 62,318,440.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,376,500.00 | 52,925,540.98 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 221,014,655.47 | 313,968,491.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,691,164.00 | 96,497,501.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийж | 24,556,456.00 | 33,599,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 123,767,035.47 | 183,871,890.50 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 187,438,497.00 | 211,519,270.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 187,438,497.00 | 211,519,270.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 187,438,497.00 | 211,519,270.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>2,104,819,771.53</u> | <u>(39,054,837.04)</u> |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>2,104,819,771.53</u> | <u>(39,054,837.04)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>4,100,096,800.00</u> | <u>5,169,901,400.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,094,096,800.00 | 5,160,508,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,898,192,400.00 | 4,916,779,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,898,192,400.00 | 4,916,779,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 195,904,400.00 | 243,728,600.00 |

| | | | |
|-------------|--|--------------------------------|--------------------------------|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 195,904,400.00 | 243,728,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>3,599,749,654.00</u> | <u>5,207,205,559.34</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,599,749,654.00 | 5,207,205,559.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,412,311,157.00 | 4,990,825,359.34 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,572,259,377.00 | 3,828,504,277.36 |
| 210101 | Үндсэн цалин | 1,706,625,359.00 | 2,413,871,896.36 |
| 210102 | Нэмэгдэл | 735,178,718.00 | 1,255,517,681.00 |
| 210104 | Урамшуулал | 130,455,300.00 | 159,114,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 357,791,600.00 | 498,073,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 243,298,000.00 | 338,689,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 28,623,500.00 | 39,845,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,898,600.00 | 19,923,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,724,700.00 | 19,923,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 57,246,800.00 | 79,691,800.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 195,904,400.00 | 243,728,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,850,237.00 | 11,397,021.86 |
| 210302 | Түлш, халаалт | 185,353,563.00 | 230,631,578.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,700,600.00 | 1,700,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 164,178,800.00 | 231,049,440.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | 164,178,800.00 | 231,049,440.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,376,500.00 | 62,318,440.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,000,000.00 | 9,392,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,376,500.00 | 52,925,540.98 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,800,480.00 | 127,151,401.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,224,980.00 | 94,071,401.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 28,575,500.00 | 33,080,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 187,438,497.00 | 216,380,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 187,438,497.00 | 216,380,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 187,438,497.00 | 216,380,200.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>500,347,146.00</u> | <u>(37,304,159.34)</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 146,175,000.00 | 75,101,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 146,175,000.00 | 75,101,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 146,175,000.00 | 75,101,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 146,175,000.00 | 75,101,000.00 |

| | | | |
|----|--|--------------------------------|-------------------------------|
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(146,175,000.00)</u> | <u>(75,101,000.00)</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 354,172,146.00 | (112,405,159.34) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 84,384,654.00 | 438,556,800.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 438,556,800.00 | 326,151,640.66 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-------------------------|-------------------------|-------|---|
| C01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 586,066,331.00 | 1,856,187,421.40 | (774,639,765.81) | | 1,667,613,986.59 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 586,066,331.00 | 1,856,187,421.40 | (774,639,765.81) | | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (8,479,992.00) | | (8,479,992.00) |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 586,066,331.00 | 1,856,187,421.40 | 1,321,700,013.72 | | - |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 586,066,331.00 | 1,856,187,421.40 | 1,321,700,013.72 | | - |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 586,066,331.00 | 1,856,187,421.40 | 1,321,700,013.72 | | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (39,054,837.04) | | (39,054,837.04) |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 586,066,331.00 | 1,856,187,421.40 | 1,282,645,176.68 | | - |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,661,119,400.00 | 5,282,306,559.34 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,661,119,400.00 | 5,282,306,559.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,440,672,300.00 | 5,065,926,359.34 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,082,187,200.00 | 3,828,504,277.36 |
| 210101 | Үндсэн цалин | 2,769,215,900.00 | 2,413,871,896.36 |
| 210102 | Нэмэгдэл | 1,153,856,600.00 | 1,255,517,681.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 159,114,700.00 | 159,114,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |

| | | | |
|---------------|--|------------------|------------------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 510,273,500.00 | 498,073,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 346,985,900.00 | 338,689,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 40,821,800.00 | 39,845,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,411,000.00 | 19,923,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 20,411,000.00 | 19,923,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 81,643,800.00 | 79,691,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 295,341,000.00 | 243,728,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,975,900.00 | 11,397,021.86 |
| 210302 | Түлш, халаалт | 275,665,100.00 | 230,631,578.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,700,000.00 | 1,700,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 240,414,400.00 | 231,049,440.00 |
| 210502 | Хоол, хүнс | 240,414,400.00 | 231,049,440.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,800,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 87,262,200.00 | 62,318,440.98 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,000,200.00 | 9,392,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 77,262,000.00 | 52,925,540.98 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 223,394,000.00 | 202,252,401.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 190,314,000.00 | 169,172,401.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 33,080,000.00 | 33,080,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 220,447,100.00 | 216,380,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 220,447,100.00 | 216,380,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 220,447,100.00 | 216,380,200.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,661,119,400.00 | 5,169,901,400.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,916,779,900.00 | 4,916,779,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,916,779,900.00 | 4,916,779,900.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 297,141,000.00 | 243,728,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 297,141,000.00 | 243,728,600.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 447,198,500.00 | 9,392,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,000,200.00 | 9,392,900.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 437,198,300.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 438,556,800.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 326,151,640.66 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 158 | 158 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |

| | | | |
|-----------|---|------------|------------|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 121 | 121 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 36 | 36 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 158 | 158 |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 117 | 117 |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 2 | 2 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 38 | 38 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Нэмэлт санхүүжилт аваагүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага.

Тайлант онд “Сургуульд хамрагдсан суралцагчийг бие даан сурч амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн турхай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд зарим өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Байгууллагын даргын 2019 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 103 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна. Уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12.5 сая төгрөгөөр буюу 0.33 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|---------------------|---------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 438,556.80 | 326,151.60 | (112,405.20) |
| Авлага | | | |
| Бараа материал | 64,621.50 | 92,166.00 | 27,544.50 |
| Үндсэн хөрөнгө | 3,260,775.50 | 3,358,193.70 | 97,418.20 |
| Нийт хөрөнгө | 3,763,953.80 | 3,776,511.30 | 12,557.50 |
| Өр төлбөр | - | 51,612.40 | 51,612.40 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,763,953.80 | 3,724,898.90 | (39,054.90) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 3,763,953.80 | 3,776,511.30 | 12,557.50 |

Мөнгөн хөрөнгийн данс 326.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч өмнөх оноос 112.4 сая төгрөгөөр буурсан байна.Цалингийн зардлаас 265.9 сая төгрөгийн, хоолны зардлын

төсвөөс 9.4 сая төгрөгийн, үдийн цайны зардлаас 4.1 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 21.8 сая төгрөгийн, БГАҮТХ-ын зардлаас 24.9 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 92.2 сая төгрөг болж 27.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 539.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, номын түрээсийн орлогоос 2.5 сая төгрөгийг оруулж, үйл ажиллагаанд 514.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 97.4 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 75.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, Боловсролын шинжлэх ухааны яамнаас 26.7 сая төгрөгийн дотуур байрны зөөлөн эдлэл, 14.2 сая төгрөгийн компьютер, 5.0 сая төгрөгийн зурагт, 55.0 сая төгрөгийн багш нарын нотебүүк, 22.1 сая төгрөгийн эко кабинетын төхөөрөмж, багш нарын хандивын мөнгөөр хийсэн 26.7 сая төгрөгийн төмөр хашаа, эцэг эхийн хандиваар ирсэн 28.7 сая төгрөгийн зурагт, 3.6 сая төгрөгийн хувцасны шүүгээг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 51.6 сая төгрөг болж нэмэгдсэн нь халаалтын зарлоын тооцооны өглөг ба орон нутгийн санхүүжилт 12 дугаар сард оройтож ирснээс гүйлгээ хийж амжаагүтэй холбоотой үүссэн байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 39.0 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,891.1 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр, зарлагын нийт дүнг 3,891.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж 339.6 сая төгрөгөөр буруулж, 3,551.5 сая төгрөгөөр баталсан байна. Батлагдсан төсвийг 2,109.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,661.1 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны төсвийн хэлбэлзлийн тайлангаар зарцуулах төсөв нь 5,661.1 сая төгрөг байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,363.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 297.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,038.6 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 243.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,169.9 сая төгрөг буюу 93 хувьтай байна. Төрийн сангийн харилцах дансанд 438.6 сая төгрөгийн их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|---------------------|---------------------|-------------------|-----------|
| 1 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 5,846.90 | 5,846.90 | - | 100 |
| 2 | Байр ашиглалтын үйлчилгээ | 7,973.00 | 7,973.00 | - | 100 |
| 3 | Хүүхэд хамгаалал | 7,976.60 | 7,976.60 | - | 100 |
| 4 | Сургалт семинар | 7,646.50 | 7,646.50 | - | 100 |
| 5 | Эрүүл мэндийг дэмжих | 11,356.60 | 11,356.60 | - | 100 |
| 6 | үдийн цай хөтөлбөр | 220,447.10 | 220,447.10 | - | 100 |
| 7 | Дотуур байрны үйлчилгээ | 775,948.00 | 775,948.00 | - | 100 |
| 8 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 75,690.60 | 75,690.60 | - | 100 |
| 9 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 25,774.30 | 25,774.30 | - | 100 |
| 10 | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 16,794.00 | 16,794.00 | - | 100 |
| 11 | Боловсролын стандарт, сургалтын | 4,010,228.10 | 3,684,827.66 | 325,400.44 | 92 |
| 12 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 171,115.30 | 171,115.30 | - | 100 |
| 13 | Сурах бичгийн түрээс | 10,000.20 | 10,000.20 | - | 100 |
| 14 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 17,181.20 | 17,181.20 | - | 100 |
| 15 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 297,141.00 | 243,728.60 | 53,412.40 | 82 |
| | Нийт дүн | 5,661,119.40 | 5,282,306.56 | 378,812.84 | 93 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ахмадын сан байгуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй байна.

Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ төсвөөс 9.4 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 169.2 сая төгрөгийг зарцуулсан.

Тус байгууллагад 2024 онд 158 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 121, үйлчлэх ажилтан 36, нийтдээ 158 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хийгээгүй байна. Сургууль нь 2024 онд 539.6 сая төгрөгийн бараа материал, 75.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,717.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 55.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,417.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 81.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 1,813.5 сая төгрөгийн 43 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 529.2 сая төгрөгийн 41 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 250.1 сая төгрөгийн 18 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 98.9 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 194.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 3.3 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлөх 1 төлбөрийн акт тогтоосон байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөрчлийг бүрэн арилгаж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-------------------|------------------------|------------------|----------|------------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 3,342.5 | 1 | 3,342.5 | 100 |
| Албан шаардлага | 2 | 194,109.1 | 2 | 194,109.1 | 100 |
| Зөвлөмж | | | | | |
| Хариуцлага тооцох | | | | | |
| Нийт дүн | 3 | 197,451.6 | 3 | 197,451.6 | 100 |

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үдийн хоолны төсвийн зарцуулалт, тооцоо, үдийн хоолонд хамрагдсан хүүхдийн бүртгэлийн баримтжуулалт, хяналтыг анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд нийт 5,821.6 сая төгрөгийн алдаа илэрч залруулга хийгдсэн. Үүнд: *Залруулсан алдаа*

- Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн эхний үлдэгдлийг 155.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж ирүүлснийг залруулав.
- Мөнгөн гүйлгээний тайланд хоол хүнсний зардлыг 5.7 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.
- ТГТ-д зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөг 1561.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 1069.8 сая төгрөгөөр, зардлын төлөвлөгөөг 1486.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 1543.2 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнаж ирүүлснийг залруулав

Аудитаар нийт 197.4 сая төгрөгийн зөрчил илэрч 12.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 211.5 сая төгрөгийн албан шаардлага, 10.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр 12.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 2 акт тогтоосон.

1. Тайлант онд нэр бүхий ажилтнуудад олгосон 2.3 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага ” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант оны үдийн хоолны зарцуулалтыг нярвын 1-9 дүгээр сарын бараа материалын тайлан, анхан шатны зарлагын баримтаар тогоочид олгосон хоол хүнсний материалын зарцуулалтыг хоолны талонтой нэг бүрчлэн тулгаж үзэхэд 10.2 сая төгрөгийн хоол хүнсний материалыг баримтгүйгээр илүү зарлага гаргаж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр 211.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, тодруулгад үдийн хоолны зардлын гүйцэтгэлийг 211.5 сая төгрөгөөр тайлагнасан байна. Үдийн хоолны зарцуулалтын тайлангаар 2024 оны 1-5 дугаар саруудын хүүхдийн тоог тогтмол 850 хүүхдээр, 9-12 дугаар саруудын хүүхдийн тоог тогтмол 886 хүүхдээр тооцож зарцуулалтыг тайлагнаж ирүүлсэн бөгөөд үдийн хоолонд хамрагдсан хүүхдийн бүртгэлийг өдөр тутам хянаж, баримтжуулж ажиллаагүй, зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх,

“Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах үйл ажиллагааг хориглоно”, 11.1.3-т “сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой баримт бичгийг хуурамчаар бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитын дүнгээр 10.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоолны зардал 231.0 сая төгрөг, үдийн хоолны зардал 216.3 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 75.1 сая төгрөг/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Анхан шатны баримт бүрдэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бусад бараа үйлчилгээний зардлын төсвөөс замын зардал, ажил үйлчилгээний хөлс, томилот зэрэгт нийт 30.3 сая төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулж, тооцоог зохих журмаар хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхийг таслан зогсоох, хууль журмыг мөрдөж ажиллаж;

Дээрх зөвлөмж болон бусад шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|--------------------|-----------------------------------|-----|--------------------------|--------------------|------------|--------------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| СБТ-д нийт хөрөнгийн эхний үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан | 1 | 155,181.9 | | | 1 | 155,181.9 | 1 | 155,181.9 | | | | |
| МГТ-д хоол хүнсний зардлыг илүү тайлагнасан | 1 | 5745.0 | | | 1 | 5745.0 | 1 | 5745.0 | | | | |
| ТГТ-д төлөвлөгөө, гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан | 4 | 5,660,630.8 | | | 4 | 5,660,630.8 | 4 | 5,660,630.8 | | | | |
| Дүн | 6 | 5,821,557.8 | | | 6 | 5,821,557.8 | 6 | 5,821,557.8 | | | | |

